



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2023 оны 01 сарын 06 өдөр

Төрийн ордон, Улаанбаатар хот

СОГТУУРУУЛАХ УНДААНЫ ЭРГЭЛТЭД ХЯНАЛТ ТАВИХ, АРХИДАН СОГТУУРАХТАЙ ТЭМЦЭХ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архидан согтуурахтай тэмцэх тухай хуульд доор дурдсан агуулгатай зүйл, хэсэг, заалт нэмсүгэй:

1/5 дугаар зүйлийн 5.10 дахь хэсэг:

“5.10.Согтууруулах ундаа үйлдвэрлэх тусгай зөвшөөрөлтэй холбогдсон энэ хуулиар зохицуулаагүй бусад харилцааг Зөвшөөрлийн тухай хуулиар зохицуулна.”

2/14 дүгээр зүйлийн 14.5.8-14.5.10 дахь заалт:

“14.5.8.энэ хуулийн 14 дүгээр зүйлийн 14.3-т заасан шинжилгээнд хамруулж, эрүүл ахуйн шаардлага хангасан талаарх баримт;

14.5.9.импортын согтууруулах ундаа хадгалах барилга байгууламжийн аюулгүй байдлыг хангах зорилгоор дүрс бичлэгийн техник, хэрэгсэл суурилуулсан талаарх цагдаагийн байгууллагын санал;

14.5.10.татварын өргүй талаар татварын байгууллагын тодорхойлолт.”

3/14 дүгээр зүйлийн 14.16 дахь хэсэг:

“14.16.Согтууруулах ундаа импортлох тусгай зөвшөөрөлтэй холбогдсон энэ хуулиар зохицуулаагүй бусад харилцааг Зөвшөөрлийн тухай хуулиар зохицуулна.”

4/15 дугаар зүйлийн 15.10 дахь хэсэг:

“15.10.Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөлтэй холбогдсон энэ хуулиар зохицуулаагүй бусад харилцааг Зөвшөөрлийн тухай хуулиар зохицуулна.”

5/15¹ дүгээр зүйл:

“15¹ дүгээр зүйл.Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөл олгох

15¹.1.Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөл хүссэн хуулийн этгээд тухайн аймаг, нийслэлийн Засаг даргад, эсхүл чөлөөт бүсийн

нутаг дэвсгэрт чөлөөт бүсийн захирагчид Зөвшөөрлийн тухай хуулийн 5.1, 5.4 дүгээр зүйлд зааснаас гадна дараах баримт бичгийг цахимаар хүргүүлнэ:

15¹.1.1.тусгай зөвшөөрөл хүссэн албан бичиг /эрхлэх үйлчилгээний төрөл, оноосон нэр, байрлах хаяг, харилцах утсыг тодорхой дурдах/;

15¹.1.2.хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар;

15¹.1.3.хяналт шалгалт хэрэгжүүлэх эрх бүхий байгууллагаас тухайн үйлчилгээний чиглэлээр үйл ажиллагааг эрхлэх талаар гаргасан улсын байцаагчийн болон ажлын байрны дүгнэлт;

15¹.1.4.тухайн үйл ажиллагааг эрхлэх байранд хийгдсэн онцгой байдлын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын галын дүгнэлт.

15¹.2.Энэ хуулийн 15¹.1-д заасан баримт бичиг эрх бүхий байгууллагад байгаа, эсхүл Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд заасан үндсэн болон дэмжих системээс татан авах боломжтой бол иргэн, хуулийн этгээдээс шаардахгүй.

15¹.3.Тусгай зөвшөөрөл олгохтой холбоотой асуудлаар дүгнэлт гаргах үүрэг бүхий ажлын хэсгийг тухайн аймаг, нийслэлийн Засаг даргын, эсхүл чөлөөт бүсийн нутаг дэвсгэрт чөлөөт бүсийн захирагчийн захирамжаар байгуулна. Ажлын хэсэг баримт бичгийн бүрдэл шалгах болон магадлан шалгах ажиллагааг Зөвшөөрлийн тухай хуулийн 5.2 дугаар зүйлд заасан хугацаанд шийдвэрлэж, зөвшөөрөл олгох эрх бүхий этгээдэд хүргүүлнэ.

15¹.4.Аймаг, нийслэлийн Засаг дарга, эсхүл чөлөөт бүсийн захирагч энэ хуулийн 15¹.3-т заасан ажлын хэсгийн дүгнэлтийг үндэслэн шаардлага хангасан хуулийн этгээдэд Зөвшөөрлийн тухай хуульд заасны дагуу согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрлийг олгоно.

15¹.5.Тусгай зөвшөөрөл олгохоос татгалзсан тохиолдолд шийдвэр гарснаас хойш ажлын хоёр өдрийн дотор үндэслэлийг тодорхой дурдсан мэдэгдлийг тухайн хуулийн этгээдэд хүргүүлнэ.”

6/15² дугаар зүйл:

“15² дугаар зүйл.Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрлийн хугацааг сунгах

15².1.Тусгай зөвшөөрөл эзэмшигч Зөвшөөрлийн тухай хуулийн 5.5 дугаар зүйлд заасны дагуу энэ хуулийн 15 дугаар зүйлийн 15.1-д заасан этгээдэд дараах баримт бичгийг хүргүүлнэ:

15².1.1.тусгай зөвшөөрлийн хугацаа сунгуулах тухай өргөдөл;

15².1.2.цагдаагийн байгууллагын тодорхойлолт;

15².1.3.хяналтын улсын байцаагчийн дүгнэлт.”

2 дугаар зүйл.Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архи дан согтуурахтай тэмцэх тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсгийн “шийдвэрлэж болно.” гэсний дараа “Тусгай зөвшөөрлийн хугацаа сунгуулахад энэ хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1, 6.1.2, 6.1.4, 6.1.5, 6.1.6, 6.1.7, 6.1.8, 6.1.10, 6.1.11-д заасан

баримт бичгийг бүрдүүлнэ.” гэж, 14 дүгээр зүйлийн 14.5 дахь хэсгийн “зөвшөөрөл хүсэгч” гэсний дараа “зөвшөөрөл шинээр авах болон хугацаа сунгуулахад” гэж, 14.9 дэх хэсгийн “болно.” гэсний дараа “Тусгай зөвшөөрөл эзэмшигчтэй байгуулсан гэрээг дүгнэсний үндсэн дээр сунгах асуудлыг шийдвэрлэх бөгөөд тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлагыг зөрчсөн тохиолдолд тусгай зөвшөөрлийн хугацааг сунгахгүй.” гэж, 15 дугаар зүйлийн 15.1 дэх хэсгийн “захирагч” гэсний дараа “энэ хуулийн 15¹ дүгээр зүйлд заасны дагуу” гэж тус тус нэмсүгэй.

3 дугаар зүйл.Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3 дахь хэсгийн “баримтална.” гэснийг “баримтлах бөгөөд 10 жилээс дээш хугацаагаар сунгахгүй.” гэж, 14 дүгээр зүйлийн 14.8 дахь хэсгийн “сунгаж болно.” гэснийг, 15 дугаар зүйлийн 15.3 дахь хэсгийн “сунгана.” гэснийг “сунгаж болох бөгөөд таван жилээс дээш хугацаагаар сунгахгүй.” гэж тус тус өөрчилсүгэй.

4 дүгээр зүйл.Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.7 дахь хэсгийн “, импортлох тусгай зөвшөөрөл олгох, сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох” гэснийг хассугай.

5 дугаар зүйл.Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2, 15.5 дахь хэсгийг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

6 дугаар зүйл.Энэ хуулийг 2023 оны 01 дүгээр сарын 06-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА

Г.ЗАНДАНШАТАР